

**ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Ц.ЦЭВЭЭНДАРИЙН 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/ д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь		
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)						
			1	2	3	4	5				
Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх											
1.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	Хэрэгжилт гүйцэтгэлээр	1.ХБГ-ын гүйцэтгэлд нөлөөлөх эрсдэлийг. -Бүтэц зохион байгуулалт; -Үйл ажиллагаа; -Хууль тогтоомж; -Мэдээллийн технологи гэсэн 4 чиглэлээр тодорхойлж гаргасан. 2.ХБГ-ын үйл ажиллагааг тогтвортой зохион байгуулахын тулд дээрх эрсдэл үүсгэж байгаа хүчин зүйл бүртэй холбоотой эрсдэл гарах магадлал, дагаврыг үр 3x3 матрицын тусламжтай гаргасан.	Нэгжийн эрсдэлийг тухай бүр тооцон, нэгжийн эрсдэлийн тогтмол баяжуулж, эрсдэлийг бууруулах, шилжүүлэх хэмжээг ажиллана.	санг арга авч	ГЕГ-ын даргын 2022 оны А/342 дугаар тушаалаар баталсан “Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын журам”-ыг мөрдлөг болгож: -нэгжийн албан хаагч нар тус журмыг судалж, ойлголтын зөрүүг арилгахаар санал солилцсон; -албан хаагч нар өөрийн хариуцсан үйл ажиллагааны эрсдэлийг олж тогтоох зорилгоор асуудлуудыг жагсаалт гарган бичиж, түүнийгээ эрэмбэлж харьцуулж байна. Мөн ХБГ-ын үйл ажиллагаатай холбоотой давуу болон дараах сул талыг гаргасан: ДАВУУ ТАЛ 1.Багаар ажиллаж, ажиллагсад хоорондын ажил үүргийг орлон гүйцэтгэх чадвартай албан хаагч нар ажилладаг. 2.Албан тушаалын чиг үүргийн хүрээнд авилга, ашиг сонирхлоос ангид байж, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигладаггүй. 3.Гаалийн байгууллагын бодлого, чиглэлийг тодорхойлоход дэмжлэг болох мөн чиг үүрэгт хамаарах мэдээ, мэдээлэл, танилцуулгыг цаг тухай бүр ажил, амралтын цаг харгалзахгүйгээр гаргаж удирдлагад хүргүүлдэг. 4.Ажлын ачаалал даах чадвартай. Энэ нь албан хаагч нарын “Ажлын зураг авалтын хуудас”-аас харагдана. 5.Ажлын бус цагаар, амралтын өдрүүдээр яаралтай мэдээ, танилцуулга бэлтгэх шаардлага тулгарахад шалтгаан тоочихгүйгээр тухай бүр ажиллаж чаддаг.	01.01 06.10	80			

6.Шаардлага тохиолдсон үед эсхүл хэн нэг нь ачаалал ихтэй байх үед өөрийн чадахаар нэг нэгэндээ туслаж, ачааллаас нь хуваалцдаг.

СУЛ ТАЛ (ХҮНДРЭЛТЭЙ АСУУДАЛ)

1.Шаардлагатай мэдээ тайлан богино хугацаанд гаргахад эрхийн хязгаарлалтай байдаг. Тухайлбал сар бүр Сангийн яаманд гаргаж хүргүүлдэг Гэрээ бүртгэлийн нэгдсэн системээс гаргах тоон мэдээллийг авах эрх байхгүй учраас СМТТ УТҮГ-т хандаж, тодорхойгүй хугацаагаар хүлээдэг.

2.Квот, ГИТ, гаалийн мэдүүлгийг татгалзах, хүчингүй төлөвт шилжүүлэх, горимд байршуулах хугацаа сунгах зэрэг нэгжийн чиг үргийн дагуу зөвхөн тухайн асуудлыг хариуцсан ГУБ нарт байх шаардлагатай эрхүүдийг өөр бусад албан хаагч нар ашиглах боломжтой байгаа эсэхийг хянах боломжгүй байдаг.

3.CAIS-т нэвтрэхдээ тоон гарын үсэг ашиглахгүй байгаа нь нууцлал, аюулгүй байдлыг хангахгүй байна.

4.CAIS-аас шаардлагатай мэдээг татаж чаддаггүй, гар ажиллагаа ихтэй. Улс хооронд дамжуулан өнгөрүүлэх горимд байршуулсан барааны мэдээллийг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд гаргаж хүргүүлэх бүрт ГЕГ-ын МТГ-ын албан хаагч нараар гаргуулдаг. Хугацаандаа хаагдаагүй манифестын мэдээг гаргахдаа програмын алдаанаас шалтгаалж CAIS-т хаагдаагүй мэт харагддаг манифестыг тусад нь ялгаж, харуулдаггүйгээс гаалийн хяналтын бүсэд хадгалагдаж байгаа барааны улдэгдлийн мэдээг CAIS-аас татаж чаддаггүй.

5.Сангийн яамнаас мэдээ, биелэлтийг хугацааг нь тулгаж, 2 цагийн дотор ирүүл эсхүл 10:10 цагт өгөөд 13:30 цагаас өмнө ирүүл гэх мэтээр шаарддаг.

Мөн бусад яамнаас санал авахаар Сангийн яаманд хүргүүлсэн төслийг хугацааг нь тулгаж ГЕГ-т ирүүлээд өнөөдрийн дотор санал өг гэсэн албан бичиг ирүүлдэг.

					Эсхүл яам болон бусад байгууллагуудаас 2024.10.15-ны өдөр албан бичиг боловсруулсан өдрөөс хойш 2 эсхүл 3 хоногийн дотор яаралтай санал ирүүл гэсэн бичигнүүдэд богино хугацаанд хариу өгөх шаардлага гардаг. Гэтэл дээрх албан бичигнүүд нь шуудангаар дундажаар 3 хоногийн дараа ирдэг.		
2	Автозамын хилийн боомтод суурцуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллага тай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Замын-Үүд гаалийн газрын Зорчигч, ачаа тээврийн шалган нэвтрүүлэх цогцолбор, Шивээхүрэн боомт, Гашуунсухайт боомтын ухаалаг гарцыг нэвтрүүлсэн. ХУН төслийн хүрээнд гаалийн байгууллага болон хил хамгаалах байгууллагын тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын системийг уялдуулж, автозамын хилийн боомтоор нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээлэл солилцох программыг Замын-Үүд боомтод туршилтаар нэвтрүүлсэн.	Ухаалаг гарцыг шинээр нэвтрүүлэх боомт болон хяналтын бүсүүдэд программ хангамжийн дэмжлэг үзүүлнэ.	<p>-Хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг RFID-ээр нэвтрүүлэхдээ эрсдэлийн удирдлагын програмд урьдчилж оруулсан шалгуурын дагуу шалгах системийг Замын-Үүд боомтын зорчигчийн терминалд 3 сарын хугацаатай туршилтаар нэвтрүүлэх асуудлыг ГЕГ-ын 2025.05.21-ний өдрийн МЗХ-д танилцуулж, шийдвэрлүүлсэн. Мөн МТГ-т:</p> <p>-Ухаалаг гарцын зааварт нийцүүлэн экспорт, импортын бараа ачих, буулгах, гаалийн хяналт, шалгалт хийх зориулалтаар ААН-ийн тогтоолгосон ГХБ-үүдэд суурцуулсан RFID тоног төхөөрөмжүүдийг гаалийн байгууллагын системтэй холбох, CAIS, CEPS, Smartgate.ecustoms.mn системд хийгдэх шаардлагатай программын даалгаврыг боловсруулж 2025.01.07-ны өдрийн 01101/13 дугаартай дотоод зурвасаар, мөн 2025.05.28-ны өдрийн 01101/337 дугаартай дотоод зурвасаар дээрх ажлыг эрчимжүүлэх талаар;</p> <p>- Эрсдэлд сууриссан зарчимд үндэслэн гаалийн хяналт, шалгалтаас чөлөөлөгдсөн (ногоон) тээврийн хэрэгсэл, зорчигчийн автобусанд зориулсан гарцыг smartgate.ecustoms.mn систем дээр хэрэглэгч өөрөө буюу ХШ хариуцсан ГУАБ тохируулдаг байх нэмэлт өөрчлөлт хийлгэхээр 2025.06.04-ний өдрийн 01101/365 дугаартай дотоод зурvas хургуулэн хамтран ажиллаж байна.</p>	01.01 06.10	80
3	Цахим нэг цонхны системийг бий болгох ажлын	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023.10.03-ны өдрийн A/184 тушаалаар байгуулагдсан Гадаад худалдааны	Цахим нэг цонхны мэдээллийн системийг бий болгох ажлын хэсэгт ажиллана.	ЭЗХЯ-ны ТНБД-ын 2023.08.10-ны өдрийн A/138 дугаартай тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан Гадаад худалдааны цахим нэг цонх" мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим	01.01 06.10	90

	хэсэгт ажиллах	цахим нэг цонх мэдээллийн системийг бий болгох, гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ХБГ, ХЦХ, МТГ-ын албан хаагч нар ажиллаж байна. Тус ажлын хэсэг 2025 оны эхний 5 сард хуралдаагүй.	хэлбэрээр үзүүлэх үйл ажиллагааг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан эхлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ХБГ, ХЦХ, МТГ-ын албан хаагч нар ажиллаж байна. Тус ажлын хэсэг 2025 оны эхний 5 сард хуралдаагүй.	Монгол улсад гадаад худалдааны харилцааг зохицуулах тарифын бус хязгаарлалтын аргаас бүртгэлийн хэлбэрийг хамгийн өргөн хэрэглэдэг бөгөөд улсын хилээр нэвтрүүлэх тодорхой нэрийн бараанд тусгай зөвшөөрөл болон бүртгэл олгох замаар төрөөс хяналт тавьж байна.	Иймд гадаад худалдаатай холбоотой дээрх зөвшөөрлийг олгодог байгууллагууд цахим нэг цонх мэдээллийн системийг ашиглаж, олон төрлийн үйлчилгээ, мэдээллийг нэг дор төвлөрүүлсэнээр гаалийн байгууллагын үйл ажиллагааг хялбарчилж, гадаад худалдаанд оролцогч нарт чирэгдэлгүй орчин бүрдүүлэхээр ажиллаж байна.	Иргэний зориулалтаар хилээр оруулах галт зэвсэгт Цагдаагийн байгууллагаас олгодог зөвшөөрлийг CAIS-т гаалийн мэдүүлэгт цахимаар татах асуудлаар ХЗДХЯ-ны мэргэжилтэн Энх-Эрдэнэ, СМТТ УТҮГ, ЦЕГ-ын төлөөлөлтэй 2025.02.11, 2025.04.29 өдөр уулзалт зохион байгуулж, дараах ажлуудыг хэрэгжүүлж байна: 1.ХЗДХЯ болон ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвөөс олгож буй тусгай зөвшөөрөл, лицензийг цахимаар олгохоор программын даалгавар боловсруулах; 2.Гаалийн байгууллагын цахим системтэй холбох, ингэхдээ БТКУС-ийн ангиллын кодоор “заавал” татахгүйгээр, эхний байдлаар шаардлагатай тохиолдолд олгосон зөвшөөрлийг мэдүүлэгт татаж оруулж байх; 3.Цаашид Галт зэвсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, галт зэвсэг, дагалдах хэрэгслийн ялгааг нарийн тодорхойлох боломжтой болсны дараа “заавал” татаж оруулдаг болгохоор програмд өөрчлөлт оруулах. Мөн галт зэвсэгийн зөвшөөрлийг гаалийн мэдүүлэгт цахимаар татах хөгжүүлэлт хийгдэж байгаатай холбогдуулан БТКУС-ийн жагсаалтыг СМТТ УТҮГ-т хургуулсэн.
--	----------------	--	---	--	---	---

4	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.	<p>1.ТОМИЛОЛТ:</p> <p>-ГЕГ-ын даргын 2025.01.09-ний өдөр баталсан удирдамжийн дагуу Баянхшуу, Бичигт боомтод 2025.01.10-2025.01.16-ны өдрийг дуустал хугацаанд ШХТ, БХ-ийн албан хаагч нарын хамт томилолтоор ажиллаж, тус боомтуудад RFID суурилуулах шаардлагатай тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, байршилын цэгийг судалж, удирдлагад танилцуулсан.</p> <p>-АҮЭБЯ-ны ТНБД-ын 2025.04.03-ны өдрийн А54 дүгээр тушаалаар байгуулагдсан Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК, Эрдэнэс критикал минералс ХХК зэрэг ААН-тэй уул уурхайн бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ байгуулсан ААН-ийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамт 2025.04.08-2025.04.12-ны өдрүүдэд Дарханд томилолтоор ажилласан.</p> <p>-ГЕГ-ын даргын 2025.04.15-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Эрээн-Замын-Үүд боомтыг 24 цагийн горимд шилжүүлэх асуудлаар 2025.04.16-2025.04.18-ны өдрийг дуустал хугацаанд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боомтын захирагааны албатай Эрээнд хийх уулзалтад оролцсон.</p> <p>-АҮЭБЯ-ны ТНБД-ын 2025.04.23-ны өдрийн А/72 дугаар тушаалаар байгуулагдсан Таван толгой ХК, Эрдэнэс таван толгой ХК зэрэг ААН-тэй уул уурхайн бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ байгуулсан ААН-ийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах ажлын хэсгийн хамт Гашуунсухайт боомтод 2025.04.23-2025.04.26-ны өдрийн хооронд томилолтоор ажилласан.</p> <p>-Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын нээлтийн үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангах хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боомтын захирагааны албатай 2025.05.12-ны өдөр Гашуунсухайт-Ганцмод боомтод газар дээр нь ажиллаж, хамтарсан уулзалт зохион байгуулах, мөн ГЕГ-ын дарга, БХ-ийн дарга нарын хамт нээлтийн үйл</p>	01.01 06.10	100
---	--------------------------	-------------------------	--	--	---	----------------	-----

ажиллагаанд оролцохоор тус боомтод 2025.05.11-2025.05.16-ны өдрүүдэд томилолтоор ажилласан.
-ГЕГ-ын даргын 2025.05.28-ны өдрийн А/227 дугаар тушаалаар БНХАУ-ын Тяньжин боомтод 2025.06.09-2025.06.17-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Тэмэр замын коридорыг хөгжүүлэх, тээвэр логистикийн салбарын хамтын ажиллагаа”-ны олон улсын уулзалтад ГУБ Д.Ням-Осорийн хамт оролцож, томилолтоор ажилласан.

2.БАТЛУУЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨР:

-Хилийн Замын-Үүд боомтод суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ГЕГ-ын дэд даргаар 2025.03.01-ний өдөр батлуулсан.

-ГИТ болон ТИР горимоор улс хооронд тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ийн албан тушаалтанд зориулсан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтын хөтөлбөрийг ГЕГ-ын ЭБАТ-тай хамтран боловсруулж, ГЕГ-ын ЗУГ-ын даргаар 2025.04.17-ны өдөр батлуулсан.

3.УУЛЗАЛТ, ХУРАЛ:

-Ландбридж ХХК-ийн төлөөлөлтэй 2025.01.07-ны өдрийн 14:00-16:00 цагт ГЕГ-т зохион байгуулсан уулзалтад оролцож, гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой асуудлаар санал солилцсон.

-КАРЕК тээврийн стратеги 2030 дунд хугацааны үнэлгээ хийхтэй холбоотойгоор АХБ-ны БНХА-ын ахлах зөвлөх Д.Өнөржаргал, Чэн чэн, Масахиро наортай 2025.02.11-ний өдрийн 17:30 цагт ГЕГ-т хийсэн уулзалтад дэд даргын хамт оролцсон.

-БНСУ-ын Хөгжлийн хүрээлэн /Korea Development Institute/ -ийн хэрэгжүүлж буй “2024/2025 Мэдлэг хуваалцах хөтөлбөр”-ийн хүрээнд ГЕГ-т 2025.03.19-ний өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсад аж үйлдвэрийг хөгжүүлэх стратеги /хүнд үйлдвэрт чиглэх/ төслийг хамтран хэрэгжүүлэх ажлын хэсгийн хуралд оролцсон.

-УИХ-ын 2022 оны Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолын е-д мал, амьтны

гаралтай болон ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эцсийн бүтээгдэхүүн хүртэл ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журмыг боловсруулан батлуулах, цахим бүртгэлийн нэгдсэн системд шилжүүлэх үүрэг өгсөнтэй холбогдуулан ГЕГ, АТҮТ хооронд мэдээлэл солилцох асуудлаар 2025.04.14-ний өдөр ГЕГ-т зохион байгуулагдсан уулзалтад оролцож, санал солилцсон.

-Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбоотой хамтран УБГГ-ын хурлын танхимд 2025.04.21-ний өдрийн 14:00-17:30 цагт тээвэрлэгч ААН-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, танилцуулга хийж, санал солилцсон.

-БСҮХ-оос зохион байгуулсан Гашуунсухайт боомт дахь нүүрсний тээвэрлэлтийг зохицуулах журмын төслийг боловсруулах ажлын хэсгийн 2025.05.07-ны өдрийн 14:00-18:00 цагийн хуралд оролцсон.

- ГЕГ-ын даргын 2025.05.08-ны өдрийн А/174 дүгээр тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар, АХБ-ны хооронд байгуулсан 4419-МОН, 4420-МОН зээлийн хэлэлцээрийн хүрээнд БСҮХ-ны Ажлын албанаас хэрэгжүүлж буй "Хилийн үр ашгийг нэмэгдүүлж, тогтвортой худалдааг дэмжих төсөл"-ийн дэд төсөл болох Хавирга боомтын өргөтгөл, шинэчлэлтийг эхлүүлэх, гаалийн хяналт, шалгалтад ашиглагдах иж бүрдэл тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, техникийн тодорхойлолтыг гаргах, иж бүрдэл тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсарч суурилуулах ажлын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, БСҮХ-той хамтарч ажиллах ажлын хэсгийн 2025.05.22-ны өдрийн 14:00 цагийн хуралд оролцсон.

- Монголын тээвэр зуучлагчдын нэгдсэн холбооноос 2025.06.05-ны өдөр зохион байгуулах "Ложистикс форум 2025" хэлэлцүүлэйт ГЕГ-ын дэд дарга Г.Энхтайван, ХБГ-ын ГУБ Д.Ням-Осор, Л.Амартувшин нарын хамт оролцсон.

4.ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ:

Тусгай зөвшөөрлийн цахим систем license.mp-ээр ГИТ-ийн хүсэлт илгээж шийдвэрлүүлсэн, мөн ТИР горимын тээвэрлэлт гүйцэтгэдэг 89 тээвэрлэгч

					AАН-ийн 90 гарыу төлөөлөлтэй 2025.05.07-ны өдөр АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран уулзалт зохион байгуулж, Гаалийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Эрүүгийн хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах сургалт зохион байгуулсан.		
5	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	- Ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлсэн.	-Ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, томилолт, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, томилолтоор ажиллах, ээлжийн амралт, чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулан, илгээнэ.	2025.01.01-2025.05.31-ний байдлаар ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлсэн: -томилолтоор ажиллах 6; -уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 12; -хурлын өрөө 1; -бусад 3 буюу нийт 22 хүсэлтийг тус тус CERP-д тухай бүр оруулан, илгээж, хянуулсан. 2025.01.01-2025.05.31-ны байдлаар CERP-д 884 минут илүү цаг ажилласан бүртгэл байна.	01.01 06.10	90

Хоёр: Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	Танилцуулга бэлтгэх	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Гаалийн хяналтын бүсэд суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэж өгсөн байна.	Засгийн газрын 2025.01.23-ны өдрийн хуралдаанд ГЕГ-ын дарга оролцохтой холбогдуулан хилийн болон гүний гаалийн хяналтын бүсэд суурилуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэж өгсөн.	01.01 06.10	100
2	Хэлэлцүүлэгт оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Хэлэлцүүлэгт оролцож гадаад худалдаанд	Монгол Улсын Засгийн газраас татварын хууль тогтоомжийг шинэчилж, боловсронгуй болгох зорилт дэвшүүлсний дагуу ГЕГ-аас 2025.01.24, 27-ны өдөр	01.01 06.10	100

				оролцогч нарт мэдээлэл өгсөн байна.	УБГГ-т зохион байгуулсан "ТАТВАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭЧЛЭЛ" сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон.		
3	Танилцуулга бэлтгэж хүргүүлэх	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Танилцуулга бэлтгэж хүргүүлсэн байна.	ААН-ээс тусгай зөвшөөрлийн цахим lisence.mn-ээр илгээсэн хүсэлтийг хүлээн авч, хянаж, шийдвэрлэхэд зарцуулсан хугацааны талаар танилцуулга бэлтгэж ЭЗХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргад 2025.02.10-ны өдөр хүргүүлсэн.	01.01 06.10	100
4	Хэлэлцүүлэгт оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Хэлэлцүүлэгт оролцож гадаад худалдаанд оролцогч нарт мэдээлэл өгсөн байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар Цагаан алт малын гаралтай түүхий эдийн экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр 2025.02.20-ны өдөр зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт ТОГ-ын дарга, ХЦХ -ын албан хаагчидтай хамтран оролцсон.	01.01 06.10	100
5	Хэлэлцүүлэгт оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	--	Хэлэлцүүлэгт оролцож гадаад худалдаанд оролцогч нарт мэдээлэл өгсөн байна.	Цагаан шонхорын жигүүр НҮТББ-ээс "Шатахуун тээвэрлэлийн үйл ажиллагаанд тулгамдсан асуудал шийдвэрлэх арга зам" сэдвээр 2025.02.21-ний өдөр зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт ХХ-ийн ГУБ П.Сүхбаатарын хамт оролцсон.	01.01 06.10	100
6	Биелэлт гаргаж хүргүүлэх	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Олон улсын конвенц"-ийн биелэлтийг гаргаж хүргүүлсэн байна.	Монгол Улс 2004 онд нэгдэн орсон "Ачааг хилээр нэвтрүүлэхэд хийх хяналт, шалгалтын нөхцөлийг уялдуулах тухай олон улсын конвенц"-ийн "Олон улсын төмөр замын тээвэрлэлтийн хилээр нэвтрүүлэх журмыг хөнгөвчлөх" 9 дүгээр хавсралтад тусгагдсан гаалийн байгууллагын чиг үүрэгт хамаарах 10 заалтын хэрэгжилтийг гаргаж, ЗТЯ-ны ТНБД-д 2025.04.04-ний өдрийн 02/1368 дугаартай албан бичгийн хавсралтаар хүргүүллээ.	01.01 06.10	100
7	Ажлын хэсэгт ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	АҮЭБЯ-ны ТНБД-ын 2025.04.23-ны өдрийн А/72 дугаар тушаалаар байгуулагдсан Таван толгой ХК, Эрдэнэс таван толгой ХК зэрэг ААН-тэй уул уурхайн бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ байгуулсан ААН-ийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах ажлын хэсэгт ажилласан.	АҮЭБЯ-ны ТНБД-ын 2025.04.23-ны өдрийн А/72 дугаар тушаалаар байгуулагдсан Таван толгой ХК, Эрдэнэс таван толгой ХК зэрэг ААН-тэй уул уурхайн бүтээгдэхүүн худалдах, худалдан авах гэрээ байгуулсан ААН-ийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах ажлын хэсэгт ажилласан.	01.01 06.10	100
8	Ажлын хэсэгт ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын даргын 2025.05.08-ны өдрийн А/174 дүгээр тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар, АХБ-ны хооронд байгуулсан 4419-МОН, 4420-МОН зээлийн хэлэлцээрийн хүрээнд БСҮХ-ны Ажлын албанаас хэрэгжүүлж буй "Хилийн үр ашгийг нэмэгдүүлж, тогтвортой худалдааг дэмжих төсөл"-ийн	ГЕГ-ын даргын 2025.05.08-ны өдрийн А/174 дүгээр тушаалаар байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар, АХБ-ны хооронд байгуулсан 4419-МОН, 4420-МОН зээлийн хэлэлцээрийн хүрээнд БСҮХ-ны Ажлын албанаас хэрэгжүүлж буй "Хилийн үр ашгийг нэмэгдүүлж, тогтвортой худалдааг дэмжих төсөл"-ийн	01.01 06.10	100

				хэсэгт байна.	ажилласан	дэд төсөл болох Хавирга боомтын өргөтгөл, шинэчлэлтийг эхлүүлэх, гаалийн хяналт, шалгалтад ашиглагдах иж бүрдэл тоног төхөөрөмжийн тоо хэмжээ, нэг бүрийн үнэ, техникийн тодорхойлолтыг гаргах, иж бүрдэл тоног төхөөрөмжийг нийлүүлэх, угсарч суурилуулах ажлын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, БСҮХ-той хамтарч ажиллах ажлын хэсэгт ажиллаж байна.		
9	Хэлэлцүүлэгт оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Хэлэлцүүлэгт оролцож гадаад худалдаанд оролцогч нарт мэдээлэл өгсөн байна.	УИХ-ын даргын 2024 оны 76 дугаар захирамжаар байгуулагдсан Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж цахилгаан дугуй /суррон/, скүүтерийн хэрэглээг зохицуулах талаар 2025.05.27-ны 09:00 цагт зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт оролцож мэдээлэл өгсөн.	01.01 06.10	100	
10	Хуулийн төсөлд санал өгөх	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Зөвшөөрлийн тухай хууль болон Гаалийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар санал хүргүүлсэн байна.	Зөвшөөрлийн тухай хууль болон Гаалийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар санал хүргүүлж, хүргүүлсэн саналтай холбоотой асуудлаар Хуулийн Хэлтсийн ГУБ Э.Ганболдтой хамт Сангийн яамны Хууль эрх зүйн газрын мэргэжилтэн Ариунболортой уулзаж, хүргүүлсэн төслийн заалтаар нэг бүрчлэн зөвлөлдөж, саналыг 2025.05.30-ны 02/2292 тоот бичгээр хүргүүлсэн.	01.01 06.10	100	
11	Хэлэлцүүлэгт оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Хэлэлцүүлэгт оролцож гадаад худалдаанд оролцогч нарт мэдээлэл өгсөн байна.	-УБГТ-аас 2025.06.03-ны өдрийн 09:00 цагаас тус газрын хяналтад үйл ажиллагаа явуулж буй гаалийн баталгаат бүс, гаалийн хяналтын бүс эзэмшигч настай хамтран зохион байгуулсан Гааль бизнесийн түншлэл асуудал-шийдэл сэдэвт уулзалт, хэлэлцүүлэгт оролцож гаалийн хяналт, бүрдүүлэлтэй холбоотой асуудлаар мэдээлэл өгсөн.	01.01 06.10	100	

Гурав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
		Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					
1.	Монгол бичгээр унших, бичих чадвараа дээшлүүлэх	Монгол бичгээр уншиж, бичих чадвараа дээшлүүлсэн байна.	Монгол бичгээр уншиж, бичих чадвараа цахим сайт ашиглан дээшлүүлсэн.	01.01 06.10	100

2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна	Шинээр гарсан дараах тогтоол, журам, зааврыг судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн: -Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 135, 140, 157, 187, 190, 191204 дүгээр тогтоол; -Засгийн газрын 2025.01.08-ны өдрийн "Монгол Улсад 2025 онд байгуулах аялал жуулчлалын арга хэмжээний нэгдсэн цаглабар" сурталчлах тухай 2 дугаар тэмдэглэл; -ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих журамд нэмэлт оруулсан ГЕГ-ын даргын 2025.01.22-ны өдрийн А/17 дугаар тушаал; -Монгол Улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2025 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого", "Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг үнэлэх аргачлал"-ыг тус тус уншиж судалсан.	01.01 06.10	100
3	"Монгол Улсын Дижитал худалдааны долоо хоног" арга хэмжээнд оролцож, сургалтад хамрагдах.	"Цахим худалдаа, Цаасгүй худалдаа, Цахим худалдааны тогтвортой байдал, Хил дамнасан цаасгүй худалдаанд блокчейнийг ашиглах нь, Цахим худалдааны бодлого, Олон улсын бодлого Монгол Улсын Цахим худалдаанд нөлөөлөх нь, Бус нутгийн Эдийн засгийн хамтын ажлын хэлэлцээр" сэдэвт сургалтад хамрагдсан байна.	ГХЯ, НҮБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар, НҮБ-ын Ази, Номхон далайн Эдийн засаг, нийгмийн комисс (АНДЭЗНК) болон Европын Холбооны Монгол Улсын Худалдааг хөгжүүлэх төслөөс "Монгол Улсын Дижитал худалдааны долоо хоног" арга хэмжээний хурээнд 2025.03.26, 27-ны өдөр "Цахим худалдаа, Цаасгүй худалдаа, Цахим худалдааны тогтвортой байдал, Хил дамнасан цаасгүй худалдаанд блокчейнийг ашиглах нь, Цахим худалдааны бодлого, Олон улсын бодлого Монгол Улсын Цахим худалдаанд нөлөөлөх нь, Бус нутгийн Эдийн засгийн хамтын ажлын хэлэлцээр" сэдвээр зохион байгуулсан сургалтад хамрагдсан.	01.01 06.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН

УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ

/Ц.ЦЭВЭЭНДАРЬ/

06
2025 ОНЫ 10 ДУГААР САРЫН -НЫ ӨДӨР.

**ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Ц.ЦЭВЭЭНДАРИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС
ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТУВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн өрөнхий газар
Нэгжийн нэр: Хяналт, бүрдүүлэлтийн газар

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1				4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

Зорилт 1. "Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт

1.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	50	5	55	
2.	Автозамын хилийн боомтод сууринуулсан ухаалаг гарцын тоног төхөөрөмжийг ашиглан хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж, хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийн бүртгэлийг нэгтгэх	50	5	55	
3.	Цахим нэг цонхны системийг бий болгох ажлын хэсэгт ажиллах	47	3	50	
4.	Үүрэг даалгаврын биелэлт	60	10	70	
5.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	

Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт

1.	Ажлын хэсэгт ажиллах	60	10	70	
2.	Танилцуулга бэлтгэх	60	10	70	
3.	Уулзалт, хурал, зөвлөгөөнд оролцох	60	10	70	
4.	Томилолтоор ажиллах	60	10	70	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
				1
1	Монгол бичгээр уншиж, бичих чадвараа дээшлүүлэх	90	13.5	
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх.	90	13.5	
Дундаж оноо			13.5	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
			1
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	6	
3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Дундаж оноо		6.6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)	
		1	2
1.	Хандлага, ёс зүй		8
2.	Багаар ажиллах		8
3.	Харилцаа		8
Дундаж оноо		8	

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлтт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт)	64.4
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13.5
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо =		
(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо	92.5	

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:

Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(Б.Даваасүрэн)

2025.06.10

(огноо)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:
Гаалийн улсын ахлах байцаагч

(Ц.Цэвээндарь)

2025.06.10

(огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:
Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

(Г.Энхтайван)

2024. 06. 10 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын
ахлах байцаагч

О.НД

(Ө.Тэгшээ)
2024. 06. 10 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга



(Р.Отгонжаргал)
2024. 06. 25 (огноо)